

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар -8

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Дараахаас аль нь үнэн бэ?

А. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероиддыг дангаар үдаан үйлдэлтэй гуурсан хоолой тэлэгч эмгүй\ хэрэглэхийг зөвлөхгүй

В. Ингаляцийн кортикостероидыг $FEV1 \geq 80\%$ өвчтөнд хэрэглэнэ

С. Хүндэвтэр зэргийн уушгины архаг бөглөрөлт өвчинтэй хүнд удаан хугацааны туршид системийн кортикостероид хэрэглэнэ

Д. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэлийн үед кортикостероидыг хэрэглэхгүй

Е. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероидыг аль болох эрт хэрэглэнэ

/2./ Дараахаас аль нь уушгины архаг бөглөрөлт өвчний хүнд сэдрэл үүсэх эрсдлийг нэмэгдүүлэх вэ?

1. Өндөр настай байх

2. Хавсарсан өвчин эмгэгтэй байх

3. Өвчин удаан хугацаанд үргэлжлэх

4. Цэргээ ханиалгах

5. Амьсгаадалт нэмэгдэх

/3./ 30-45 насны хүнд уушгины эмфизем үүсэх шалтгаан юу байж болох вэ?

1. Тамхи татах

2. Агаарын бохирдол

3. @1-антитрипсины дутагдал

4. Үлээвэр хөгжим үлээх

5. Гуурсан хоолой тэлэгдэх

/4./ Уушгинд тархмалаар хуурай хэржигнуур сонсогдох шалтгааны:

1. Багтраа өвчин

2. Уушгины хаван

3. Уушгины архаг бөглөрөлт өвчин

4. Уушгины фиброз

5. Уушгины завсрын эдийн үрэвсэл

/5./ Хөхрөлт үүсэх механизм:

А. Гемоглобин буурах

Б. Захын судас нарийсах

С. Захын судас тэлэх

Д. Оксигемоглобин буурах

Е. Эритропени

/6./ Рестриктив хэлбэрийн агааржилтын дутагдлын үед уушгины агааржилтын ямар үзүүлэлт багасах нь ач холбогдолтой вэ?

- A. Амьсгалын эзлэхүүн
- B. Ушгини үлдэгдэл агаарын эзлэхүүн
- C. Ушгини амьдралын багтаамж
- D. Ушгини нийт багтаамж
- E. Ушгини үйл ажиллагааны үлдэгдэл багтаамж

/7./ Ушгини сурьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:

- 1. Ходоод, дээд гэдэсний шархлаа
- 2. Чихрийн шижин
- 3. Силикоз
- 4. Лимфогранулематоз
- 5. Артерийн гипертензи

/8./ Дараахас бусад нь багтраа өвчнийг тодорхойлно

- A. Багтрал вентолин цацлагаар хэрэглэхэд намдана
- B. Цэрэнд Шарко2Лейдены талст илэрч болно
- C. Ушгини эмфизем үүснэ
- D. Багтрал сунжрахад нойтон хэржигнүүр сонсогдоно
- E. Өвчин аль ч насанд үүсч болно

/9./ Сурьеийн микобактерийг ямар аргаар будсан наалдацанд илрүүлэх вэ?

- A. Метилен хөх
- B. Грам
- C. Циль-Нильсон
- D. Романовский-Гимзе
- E. Лейшман

/10./ Цэрэнд эозинофили тодорхойлогдож болох шалтгаан

- 1. Багтраа
- 2. Аспергиллём
- 3. Гадаад шалтгаант харшлын альвеолит
- 4. Ушгини архаг бөглөрөлт өвчин
- 5. Ушгини сурьеэ

/11./ БАӨ-ий үед MDRD –аар ТШХ тодорхойлоход хэрэглэгдэхгүй үзүүлэлт аль вэ?

- 1. Сийвэнгийн креатинин
- 2. Биеийн жин
- 3. Нас
- 4. Креатинины клиренс
- 5. Хүйс

/12./ Изотопт Ренограммын бүрэлдэхүүн хэсгүүдэд юу орох вэ?

- 1. Судасны үе
- 2. Шүүрлийн үе
- 3. Ялгаруулах үе
- 4. Эхлэх үе
- 5. Паренхмийн үе

/13./ Шээний шинжилгээнд ямар төрлийн бортгонцор илэрвэл хэвийн гэж үзэх вэ?

- A. Гиалин
- B. Зернистый
- C. Восковидный
- D. Эритроцитын
- E. Лейкоцитын

/14./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.

- A. Бөөрний хавдар
- B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах
- C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх
- D. Архаг гломерулонефрит
- E. Бөөрний унжилт

/15./ Шээс ялгаралтын доорхи өөрчлөлтийг Анури гэнэ

- 1. Шээс огт ялгарахгүй байх
- 2. Хоногт 600 мл –ээс бага шээх

3. Хоногт 100 мл-ээс бага шээх

4. Ойр ойрхон шээх

5. Шээсний сувээр өвдөх

/16./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?

A. Полиури

B. Никтири

C. Поллакури

D. Дизури

E. Анури

/17./ Нефрозийн кризийн гол шалтгаан

A. Цусны даралт ихсэх

B. Цустай шээх

C. Хэт их хавагнах

D. Зүрхний дутагдал

E. Тархи хавагнах

/18./ Архаг гломерулонефритийн үед даавар эмчилгээ хийх гол заалт

1. Гематури

2. Артерийн даралт ихдэлт

3. Бөөрний дутагдал

4. Нефroz хам шинж

5. Сэдрэлээс сэргийлах зорилгоор

/19./ Пиелонефритийн хамгийн түгээмэл тохиолдох үүсгэгч нь аль вэ?

1. Стрептококк

2. Клебсиелл

3. Бактерууд

4. Гэдээний савханцар

5. Вирусууд

/20./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.

A. Протеинури

B. Гематури

C. Цилиндрури

D. Хаван

E. Артерийн даралт ихсэлт

/21./ СРТ нь бөөрний эмгэг судлалын практикт өргөн хэрэглэгддэг хоёр бөөрний үйл ажиллагааг харьцуулан судалдаг рентген шинжилгээний арга мөн.

/22./ Жирэмсний үед дааврын зохицуулага алдагддаг. Үүний нөлөөгөөр бөөрний судас, аяганцар, тэвшинцэрийн тонус алдагдаж шээсний урсгал удаашран пиелонефритээр өвчлөх нь элбэг байдаг

/23./ H.pylori устгах 7 хоногийн эмчилгээний дараа ямар эмийг хэд хоног уулгавал эмчилгээний үр дүн илүү вэ?

A. Ходоодны хүчил багасгах, салст хамгаалах бэлдмэл 7 хоног

B. Салст хамгаалах бэлдмэл 14 хоног

C. Хүчил бууруулах бэлдмэл 7 хоног

D. Ходоодны хүчил багасгах, салст хамгаалах бэлдмэл 14 хоног

E. Салст хамгаалах бэлдмэл 7 хоног

/24./ Цөсний хүүдийн PH хэвийн үедээ хэд байх вэ?

A. 3.5-4.5

B. 4.5-5.6.

C. 5.7-6.7.

D. 6.6-7.5.

E. 7.6-8.6.

/25./ Энтретийг үүсгэх гол шалтгаанд аль нь орохгүй вэ?

- A. Хорт бодис
- B. Халдвэр
- C. Туяаны хордлого
- D. Эмийн нөлөө
- E. Суугаа ажил

/26./ Элэгний комын үеийн Глазгогийн шалгуураар хэдэн оноотой байвал хүнд зэргийн энцефалопати гэж үздэг вэ?

- A. 8
- B. 9
- C. ≥ 10
- D. ≥ 11
- E. ≤ 12

/27./ Хэрвээ 6 сараас дээш хугацаагаар HCV+; HCV RNA титр $>10,5$ copy/ml; трансаминазууд 2 дахин ихэссэн, элэгний биопсид үрэвслийн идэвхжил (үхжлийн оноо >4) бол оношийг тавина уу

- A. HCV идэвхгүй тээгч
- B. Элэгний архаг үрэвсэл C
- C. Эдгэрсэн элэгний архаг үрэвсэл C

/28./ Малори-Вейсийн хам шинжийн шалтгааныг дурдана уу?

- 1. Их хэмжээтэйгээр ялангуяа архи уусаны дараа бөөлжих
- 2. Уян дурангийн ажилбар
- 3. Хүнд юм өргөх
- 4. Хураагуур судасны өргөсөл
- 5. Ходоод улаан хоолойн сөөргөө

/29./ Ходоод, дээд гэдэсний I хэлбэрийн байрлалтай шархлаанд ходоодны ямар хэсгийн шархлаанууд хамаардаг вэ?

- 1. Бага махир
- 2. Урд хана
- 3. Их махир
- 4. Арын хана
- 5. Ходоодны дээд өнцөг

/30./ Нойр булчирхайн цочмог үрэвсэл үүсгэж болох эмүүд аль нь вэ?

- 1. Кортикостероид
- 2. Салофалк
- 3. Индометацин
- 4. Оротат кали
- 5. H2 блокатор

/31./ ERCP шинжилгээний тусламжтайгаар хийх дурангийн эмчилгээнүүдийг нэрлэнэ үү?

- 1. Цөс нойр булчирхайн сувгийн нарийслыг тэлэх
- 2. Сувгаас чулуу гаргаж авах
- 3. Сувгийн чулууг бутлах
- 4. Цөсний хүүдий авах
- 5. Ходоодны шархны цус тогтоох

/32./ Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн түргэсгэх эмийг сонгоно уу?

- 1. омепразол
- 2. мезим форте
- 3. ношпа
- 4. фосфолюгель
- 5. пурген

/33./ Цөсний цоргонд саад үүссэн үед баас цагаан гарна. Учир нь холбоот билирубин гэдэс рүү ордоггүй

/34./ Нарийн гэдсэнд хоол боловсролт хөндийн ба ханын хоол боловсруулалт, шимэгдэлт гэсэн З үе шаттай явагдана. Эдгээрт энтероцит эсээс ялгарах ферментээс гадна гэдэсний шүүсэнд агуулагдах ферментүүд оролцно.

/35./ Инсулины шүүрэл эрүүл хүнд хэзээ ихсэх вэ?

- А. унтах байхад
- Б. хоол идсэний дараа шууд ихсэнэ
- С. хоол идсэнээс хойш хэдэн цагийн дараа
- Д. өлөн үед
- Е. сэтгэл хөдөлсөн үед

/36./ Чихрийн шижин хэвшинж 2 үүсэх нь дараах эмгэг жамаар тайлбарлагдана.

- А. β эсийн деструкци
- В. β эсийн эсрэг эсрэг бие үүсэх
- С. Сибулинд дөжрөх
- Д. Инсулины эсрэг дааврууд ихсэх
- Е. Бүгд зөв

/37./ Гипокортицизмын эмчилгээнд алийг сонгох вэ?

- А. Хлодитан
- Б. Дофаминыг дэмжих бэлдмэл
- С. Кортикостероидын синтезийг дарангуйлах
- Д. Серотонины эсрэг бэлдмэл
- Е. Кортизолыг орлуулах эмчилгээ

/38./ Тархмал хордлогот бацуугийн хордлогын дунд зэргийн шалгуурыг хэлнэ үү

- А. зүрхний агшилтын тоо 1мин-д 120 ба түүнээс дээш
- Б. хөдөлмөрийн чадвар бүрэн алдагдсан
- С. зүрхний агшилтын тоо 1 мин-д 100-120 удаа
- Д. бамбайн хордлогын криз үүсэх
- Е. зүрхний агшилтын тоо 1 мин-д 80-100 удаа

/39./ Таргалалтын үед зүрх судасны талаас гарах эмнэлзүйн шинжийг сонгоно уу

- А. Тахикарди
- Б. Зүрхний оройн түлхэлт тод
- С. Зүрхний авиа тод
- Д. Зүрх зүүн тийш томроно
- Е. Даралт буурна

/40./ Чихрийн бус шижингийн үед хийгдэх эмчилгээнүүдийг сонго.

1. хоол эмчилгээ
2. Минерин
3. Инсулин
4. Десмопрессин
5. Хөдөлгөөн

/41./ Ази эрэгтэй ба эмэгтэй хүний бүсэлхийн тойрог хэдэн сантиметрээс дээш бол төвийн таргалалт гэж үзэх вэ?

1. >102 см ба >94 см
2. >102 см ба >88 см
3. >94 см ба >88 см
4. >90 см ба >80 см
5. >88 см ба >80 см

/42./ Кетоацидозын комд орсон өвчтөнийг эрчимт эмчилгээний тасагт эмчилнэ. Учир нь кетоацидозын үед бодисын солилцооны гүнзгий хямрал үүсдэг, амьдралын чухал эрхтний үйл ажиллагаа алдагдан, амь насанд аюултай байдал үүсдэг.

/43./ Артерийн гипертензийн баруун ховдлын томрол үүсдэг. Баруун ховдлын томролыг ЗЦБ-р оношлодог.

/44./ Зүрхний цочмог шигдээсийн эмчилгээтэй холбоотой зөв мэдээлэлийг сонгоно уу?

1. Атенопол нь гэнэтийн үхлийн эрсдлийг бууруулна
2. Стретокиназа ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээсийн үед хэрэглэх заалттай
3. Стретокиназа тарьсан тохиолдолд том молекулт гепариныг хэрэглэнэ

4. Аспирин нь нас баралтыг бууруулдаггүй
5. Нифедипиниг уухаар хэрэглэнэ
- /45./ Зүрхний ишеми өвчний үед нитратын бүлгийн эмийн бэлдмэлийг хэрэглэхэд ямар гаж нөлөө илэрдэг вэ?
1. Ханиалгах
 2. Эмэнд тэсвэрлэг шинж чанар үүсэх
 3. Бөөлжис цутгах
 4. Толгой өвдөх
 5. Хоолонд дүргүй болох
- /46./ Зүрхний архаг дутагдлын үеийн хэт авиан шинжилгээнд хамааралтай зөв хариултыг сонгоно уу?
1. Зүрхний ишеми өвчний үед диастолын үйл ажиллагаа эхэлж алдагддаг
 2. Миокардын агших чадварыг цацалтын үзүүлэлтээр (EF) үнэлнэ
 3. Цацалтын үзүүлэлт <40% байх нь систолын үйл ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ
 4. Диастолын үйл ажиллагааг үнэлэх гол арга
 5. Эмчилгээ эхлэхээс өмнө шинжилгээг заавал хийх хэрэгтэй
- /47./ Хэрэхийн кардитын үед...
1. Рентген шинжилгээнд зүрхний томрол илэрнэ
 2. Перикардитын үед чагнахад шүргэлцэх чимээ сонсогдоно
 3. Зүрхний дутагдлын шинж илэрч болно
 4. Хамгийн түгээмэл тохиолддог хавхлагын эмгэг нь митрал хавхлагын нарийсал
 5. Зүрхний шуугиан сонсогдоно
- /48./ Халдварт эндокардитын үед ямар эмчилгээ хамгийн чухал вэ?
- A. Дархлаа дэмжих
 - B. Үрэвслийн эсрэг
 - C. Хордлого тайлах
 - D. Антибиотик
 - E. Харшлын эсрэг
- /49./ Симвастатин нь...
1. Зүрхний ишеми өвчнөөс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй
 2. Хэрэглэхэд булчин өвдөх гаж нөлөө илэрнэ
 3. Элэгний трансаминазууд тогтмол ихэсдэг тохиолдолд хэрэглэхийг хориглоно
 4. Жирэмсэн үед хэрэглэхэд аюулгүй
 5. Өглөөний цагт хэрэглэнэ
- /50./ Дараах оношлогооны аргуудаас аль нь миокардын ишемийг эрт оношлох боломжтой вэ?
- A. Зүрхний цахилгаан бичлэг
 - B. Зүрхний хэт авиан шинжилгээ
 - C. Анамнез
 - D. Зүрхний ачаалалтай бичлэг
 - E. Сийвэнд фермент үзэх
- /51./ Ямар ч өвдөлтгүй, эмнэл зүйн илрэлгүй хүмүүст титэм судасны эмгэгийг илрүүлэх зорилгоор эмийн сорилтой зүрхний хэт авиан оношлогоо хийдэг. Ямар эмийн бэлдмэлийг энэхүү сорилд түлхүү ашигладаг вэ?
- A. Пропранолол
 - B. Добутамин
 - C. Атропин
 - D. Допамин
 - E. Нитроглициерин
- /52./ Гипертензийн кризын үед АД-н түвшинг эхний 2 цагт хэдэн хувиар бууруулвал тохиромжтой вэ?
- A. 20%-р
 - B. 35%-р
 - C. 10%-р
 - D. 15%-р
 - E. 25%-р

/53./ Нитроглицерины гол гаж нөлөөг заана уу

- A. Бөөлжис цутгах
- B. Суулгах
- C. Ханиалгах
- D. Толгой өвдөх
- E. Хоолонд дүргүй болох

/54./ Шөнийн пароксизмын гемоглобинури (ШПГУ) ямар генийн мутациас үүсдэг вэ?

- A. GPI
- B. PIG-A
- C. PNH
- D. DAF
- E. HRF

/55./ Угаасан улаан бөөмийг ямар заалтаар хэрэглэдэг вэ?.

1. Олон удаа цус сэлбүүлж байгаа өвчтөнд цагаан эсийн дархлаа тогтооос сэргийлэх зорилгоор
2. Сийвэнгийн уургуудад мэдрэгшсэн өвчтөнүүдэд
3. Урьд нь улаан эсийн бэлдмэл сэлбүүлэхэд урвал өгч байсан өвчтөнд
4. Архаг цус багадалт
5. Гематокрит <21%-иас буурсан тохиолдолд хэрэглэнэ.

/56./ Төмрийн нөөц барагдах үеийг сонгоно уу?

- A. Төмөр дутагдлын цус багадалтын үеийн эмнэлэүй, лабораторын шинж илрэх үе
- B. Сийвэнгийн Fe багасаж, гемоглобин хэвийн байх
- C. Сийвэнгийн ферритин багасаж, Fe, гемоглобин хэвийн байх
- D. Сийвэнгийн ферритин багасаж, төмөр ихсэх
- E. Сийвэнгийн төмөр ихсэж, ферритин ихсэх

/57./ Удамшлын микросферацитоз өвчний үед илрэх шинжилгээг сонгоно уу?

1. Гиперхромын макроцитын ЦБ, гипербилирубинеми, ретикулоцитоз
2. Гипохромын микроцитын ЦБ, гипербилирубинеми
3. Нормохромын нормоцитын ЦБ, гипербилирубинеми
4. Ретикулоцитоз, микросферацитоз
5. Ретикулоцитопени, гипербилирубинеми

/58./ Удамшлын микросферацитоз өвчний үед цус задрал хаана явагдах вэ?

- A. Эдийн доторх цус задрал явагдана
- B. Судсан дотор цус задрал явагдана
- C. Холимог цус задрал явагдана
- D. Ясны чөмөгт явагдана
- E. Аль нь ч биш

/59./ Гемофили А өвчнийг дараах өвчнөөс ялган оношлоно.

- A. Виллебрандын өвчин
- B. Аутоиммуны тромбоцитопени
- C. V факторын дутагдал
- D. Хурц лейкоз
- E. Ревматойдный полиартрит

/60./ Фенюолсийн төмрийн агууламжийг сонгоно уу?

- A. 10мг
- B. 162мг
- C. 150мг
- D. 100мг
- E. 50мг

/61./ Умайн жигд биш агшилтийн үед ямар эмчилгээг хийх вэ?

- A. Өвчин намдаах, агчилт тавиулах эмчилгээ
- B. Төрөх хүчийг дэмжих
- C. Хүлээн ажиглах
- D. Төрөлтийг яаралтай кесар хагалгаагаар явуулна
- E. Сулрал гэж үзэж сэдэх эмчилгээ хийнэ

/62./ Жирэмсэнг эрт хугацаанд оношлох орчин үеийн шинжилгээний аргуудад хамаarahгүй арга:

- A. Гэрлийн арга
- B. Биологийн арга
- C. Дархлааны арга
- D. Чанд авиан шинжилгээний арга
- E. Химийн арга

/63./ Урагт бүтэлт үүссэн шинж:

- 1. Ургийн ус зунгагтай гарах
- 2. Ургийн хөдөлгөөн буурах
- 3. УЗЦ 1 хоромд 160 удаа
- 4. КТГ хожуу децелераци
- 5. КТГ д түргэсэл байхгүй байх

/64./ Хожуу гестоз үүсэх механизмыг тайлбарлана уу:

- 1. Олон эрхтний дутмагшил
- 2. Тархи хавагнах
- 3. Цусны бичил алдагдах
- 4. Судасны эндотелийн үйл ажиллагаа хямрах
- 5. ДВС

/65./ Үсжилт үүсгэдэг эмгэгийг нэрлэнэ үү

- 1. АГС
- 2. Гипотиреоз
- 3. Штейна-Левентал хам шинж
- 4. Иценко-Кушингийн өвчин
- 5. Өндгөвчийн кистома

/66./ Дайврын архаг үрэвсэлтэй эмэгтэйчүүдэд умайн цус алдалт өндгөвчний үйл ажиллагааны ямар хэлбэрийн хямралаар голдуу үүсч болох вэ?

- A. Гүйцэд боловсорсон үрийн цэврүү удаан хадгалагдсанаас
- B. Үрийн цэврүү гүйцэд боловсорч чадалгүй сөнөрснөөс
- C. Гүйцэд боловсорсон шар бие удаан хадгалагдснаас
- D. Өндгөвчинд үрийн цэврүү ерөөс үүсч боловсроогүйгээс
- E. гүйцэд боловсорсон шар бие үүсээгүйгээс

/67./ Цээжний битүү гэмтэл нь ушигны гэмтэлтэй хавсарсан үед ерөнхий унтуулга хийх аргын онцлог

- A. Уушгийг хиймэл амьсгалд түргэн шилжүүлэх
- B. Цээжний хөндийд урьдчилан гуурс тавих
- C. Судсаар наркоз хийх
- D. Хэсэг газрын мэдээг алдуулан, хагалгаа хийх
- E. Нугасны мэдээ алдуулт хийх

/68./ Элэгний поликистозын /уйланхай өвчин/ үед хийх хагалгааны тохиромжтой хэмжээг сонгоно уу?

- A. Элгийг анатомийн бус тайрах
- B. Элгийг анатомаар нь тайрах
- C. Мулзлан авах /Эпуклеаци/
- D. Гадна оёдол тавих-гуурс тавьж гадагшлуулах
- E. Уйланхайгчөлөөлөн, хальсыг үлдээх

/69./ 2 хавтаст хавхлагын дутагдлын эмнэл зүйн гол шинж

- A. Амьсгаадалт
- B. Тахикарди
- C. Зүрх орчим өвдөх
- D. Ушигны хаван, цустай цэр
- E. Нэг ба хоёр зөв

/70./ Хахаж дугарч, амьсгалж чадахгүй, ухаантай байгаа осолдогчид үзүүлэх тусlamжийн удирдамжид хамаarahгүйг нь тэмдэглэнэ үү?

- A. Сээрэн дээр 5 удаа дэлсэх
- B. Аюулхайг бүслэн шахах (5 удаа)

- C. Дээрх ажилбарыг давтан хийх
- D. Амилуулах амьсгалуулалт хийх
- E. Амилуулах суурь тусламж эхлэх

/71./ Зүрх зогсоход хүргэдэг осол гэмтлийн үндсэн шалтгаануудыг тэмдэглэнэ үү?

- 1. Зам тээврийн осол
- 2. Живэх
- 3. Угаартах
- 4. Хордох
- 5. Хахах

/72./ Дексаметазоны ямар давуу талыг ба ямар үйлчилгээг хөнгөвчлөх эмчилгээнд хэрэглэдэг вэ?

- 1. Хоолны дуршил сайжруулах үйлчилгээ
- 2. Тураалын эсрэг үйлчилгээ
- 3. Үрэвслийн эсрэг үйлчилгээ
- 4. Цусны сахар багасгах үйлчилгээ
- 5. Ходоод хамгаалах үйлчилгээ

/73./ Хэвтрийн цооролтын 4-р шат хэр гүн байдаг вэ?

- A. Арьсны дарагдсан хэсэг буцаж цайрдаггүй улайлт
- B. Арьсны улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаг улайлт
- C. Арьсны эпидермис зулгарсан эсвэл цэврүүтсэн, өнгөж хонхор үүссэн байх
- D. Арьс ба арьсан доорх өөхөн эд хүртэл шархалсан
- E. Арьс, арьсан доорх өөхөн эд ба булчингийн хальс нэвт цоорч, булчин, яс үе мөчид хүрсэн

/74./ Ахимаг эмэгтэйн биеийн жин 84кг, хөлийн хуруу бадайрч, эрээн булчин янгинана. Өвдөлт хөдлөх, ханиахад сэдэрнэ. Мэдрэлийн үзлэгээр: алга, тавхайн хүч 4 балл орчим, шуу сарвууны болон өвдөг, борвины рефлексүүд үүсэхгүй. Доргионы болон өвдөлтийн мэдрэхүй алга, тавхайд буурсан. Таны урьдчилсан онош:

- 1. Суудлын мэдрэлийн өвдөлт
- 2. Хязгаарын олон мэдрэлийн хамшинж
- 3. Бодисын солилцооны артрит
- 4. Бодисын солилцооны полиневропати
- 5. Бүсэлхийн ууцны радикулопати

/75./ Гарын сарвуу, тавхайн хүч буурч, булчингууд хатингиршсан. Тэнцвэр муу, харанхуйд илүү бүдчинэ. Хамшинжийн онош:

- A. Ёзоорын хамшинж
- B. Полиневритын хамшинж
- C. Дөрвөн мөчний сул саа
- D. Тэнцвэргүйдэл
- E. Мононеврит хамшинж

/76./ Анхдагч сүрьеэгээр голдуу ямар насыхан өвчилдөг вэ?

- A. Өндөр настангууд
- B. Бага насы болон өсвөр насы хүүхэд
- C. Залуу насыхан
- D. Идэр насыхан
- E. Дээрхи бүгд

/77./ Туберкулем голдуу хаанаас задардаг вэ ?

- A. Төвөөс
- B. Захаас
- C. Ирмэгээс
- D. Зах ирмэгдүү, гадагшлуулагч бронх байгаа хэсгээс
- E. Дээрхи бүгд

/78./ Ушигны голомтот сүрьеэгийн хүндрэлүүдийг нэрлэнэ үү ?

- 1. Нэвчдэст сүрьеэ
- 2. Плеврит
- 3. Хөндийт сүрьеэ
- 4. Туберкулема

5. Сорвигт голомтот сүрьеэ

/79./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?

1. Шууд хяналттай эмчлэх
2. Үр дүнгийн хяналт хийх
3. Гаж урвалын хяналт хийх
4. Биеийн жингийн хяналт
5. Цусны ерөнхий шинжилгээ хийх

/80./ Аденовирусийн халдварт ямар замаар дамжин халдвартлах вэ?

- A. Парентераль зам
B. Вирус тээгч
C. Цусаар, агаар дуслаар
D. Өвчтэй хүн

E. Агаар дуслын зам, хоол боловсруулах зам

/81./ Балнад өвчний үед арьсанд тууралт гарах хугацааг тэмдэглэнэ үү?

- A. Өвчний 2-7 хоногт
- B. Өвчний 8-10 хоногт
- C. Өвчний 14-20 дахь хоногт
- D. Өвчний 21-с дээш хоногт
- E. Өвчний эдгэрэх үед

/82./ Томуу өвчний эхлэл үеийн шинжүүдийг нэрлэ.

1. 38.5-40 хэм хүрч халуурна
2. Толгой өвдөнө
3. Үе мөч, булчингаар шархирч өвдөнө
4. Ханиалгана
5. Хамар битүүрнэ

/83./ Халдварт хордлогын шок үүсэж буй гол механизм нь:

1. Бодисын солилцооны гаралтай хүчилшил,
2. Судсан дотор цус түгэн бүлэгнэх хамшинж
3. Эд эсийн хүчилтөрөгчийн дутал
4. ТМТ-ы хордлого
5. Бичил эргэлтийн хямрал

/84./ Шар толбо харааны мэдрүүлийн зээрэнцгийн хооронд венийн судас гүрийж махирлах шинжийг

- A. Салюс Гунн – 1 шинж
B. Салюс Гунн – 2 шинж
C. Салюс Гунн – 3 шинж
D. Гвистын шинж
E. Голдманн шинж

/85./ Хэрлэг өвчний үед торлогт ямар өөрчлөлт илрэх вэ?

1. Ретинит
2. Васкулит
3. Нейроретинит
4. Нейроваскулит
5. Шар толбоны хаван

/86./ Ямар тохиолдолд шинж тэмдгийн гипертензи үүсдэг вэ?

1. Глаукомациклитын криз
2. Дараттай увейт
3. Тархины диэнцефалит
4. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг
5. Төрөл бүрийн хордлого

/87./ Хамраас цус алдах хэсэг газрын шалтгаануудыг нэрлэнэ үү

1. Хамрын гэмтэл
2. Хамраа хуруугаар ухах
3. Хамрын таславчийн мурийлт
4. Гадны биет
5. Хамрын хөндийн хавдрууд, хавдар төст үүсгэвэр

/88./ Стридор гэж юу вэ?

- A. Амьсгал бачуурах
- B. Амьсгал бачуурч дуу сөөх
- C. Төвөнхийн хөндий гэнэт нарийсах
- D. Төвөнхийн хөндий нарийссанаас болж амьсгалах үндсэн үйл ажиллагаа алдагдах
- E. Дууны хөвч гэнэт саажих

/89./ Хөхлөг сэргийн нь чамархайн ясны ар хэсэг бөгөөд дотроо хийтэй олон сархиагт хөндийнөөс тогтдог (1), уг сархиагт хөндийнүүд нь хэнгэргэн хөндийтэй холбогдож сонсголын үйл ажиллагааг дэмждэг (2).

/90./ Настанг ганцаардал, сэтгэл гутралаас сэргийлэхийн тулд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

- 1. Тэтгэвэрт гарсанаар гавьяаныхаа амралтыг эдэлж, сэтгэл хангалиун байх
- 2. Ач, зээ нарынхаа амьдрал, хүмүүжилд идэвхитэй оролцож байх. Тэд нартаа сайхан дурсамжуудаасаа ярьж өгөх, зурагтай альбомоо тайлбарлах, ном уншиж өгч байх.
- 3. Ахмадын клубт очиж шатар, даалуу, бильярд тоглодог байх, явган аялал, гүйлтийн марафонд оролцох.
- 4. Хүүхдүүдтэйгээ цэвэр агаарт зуслан гарч жимс, мөөг түүх, загасчлах
- 5. Өрхийн эмчийн сайн дурын туслагчаар ажиллаж, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход оролцох.

/91./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдрүүт боргоцой шиг ургацтай. Гүвдрүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний үеэр явахад өвддөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/92./ Чихрийн шижинг эмчлэхгүй бол настанд ямар хор уршигтай вэ?

- 1. Их ууж, шээсээр их чихэр алдаж буй тул настан турж эцэх магадлалтай.
- 2. Цусны сахар байнга их байх нь нүдний судасны эмгэгийг үүсгэж, тэрээр хараа муудах, сохрох аюултай
- 3. Цусны сахар байнга их байх нь хөлний судасны эмгэг үүсгэж хөлний хумс, арьс харлан үхжих аюултай тул хөлөө тайруулахад хүргэдэг
- 4. Зүрхний шигдээс үүсэх магадлал ихэсдэг
- 5. Арьс хуурайшиж, гэмтэх, хатиг, батга зэрэг идээт үрэвсэл үүсэх магадлал ихэсдэг.

/93./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Антибиотик
- B. Даавар эмчилгээ
- C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- E. Гепарин эмчилгээ

/94./ Ревматоид артритын оношлогоонд аль шинжилгээ чухал вэ:

- 1. ANA
- 2. RF

3. Anti-ds-DNA

4. Anti-CCP

5. ASO

/95./ Остеоартритын шалтгааныг тодорхойлно уу?

1. Удамшил

2. Биеийн жингийн индекс их байх

3. Урьд өмнө нь гэмтэл авсан бол

4. HLA-B27

5. Шалтгаан тодорхойгүй

/96./ Эрхтэн тогтолцооны хатуурлын ушигны талаас илрэх өөрчлөлтийг нэрлэнэ уу:

1. Ушигны абсцесс

2. Ушигны завсрын эдийн өвчин

3. Плеврит

4. Ушигны гипертензи

5. Ушигны хавдар

/97./ Яс үений үрэвслийн (Osteoarthritis) үед зонхилон гэмтэх үеийг заана уу.

1. Бугуй

2. Өвдөг

3. Тохой

4. DIP

5. MCP

/98./ Үений мөгөөрс нь цус тунгалагийн судсаар баялаг байдаг учир нөхөн төлжилт хамгийн сайн байдаг.

/99./ Уян мөгөөрс биеийн хаана байх вэ.

1. Чихний дэлбэн

2. Төвөнхийн жижиг мөгөөрс

3. Евстанхын гуурсны хана

4. Тойгны дотор хана

5. Үений уут

/100./ Хэрх төст үений үрэвслийн (Rheumatoid arthritis) үед RF хэдэн хувьд эерэг байх вэ .

А. Нийт өвчний 80 хувьд эерэг байна.

Б. Нийт өвчний 20-40 хувьд эерэг байна.

С. Сөрөг байна.

Д. Улаан эсийн тунах хурд ихэссэн үед эерэг байна.

Е. Нийт өвчний 60 хувьд эерэг байна.

Сорилын зөв хариулт

1-A, 2-B, 3-B, 4-A, 5-D, 6-C, 7-A, 8-D, 9-C, 10-A, 11-C, 12-A, 13-A, 14-D, 15-B, 16-E, 17-C, 18-D, 19-D, 20-D, 21-E, 22-A, 23-D, 24-E, 25-E, 26-E, 27-B, 28-A, 29-E, 30-C, 31-A, 32-D, 33-A, 34-A, 35-B, 36-C, 37-E, 38-C, 39-D, 40-C, 41-D, 42-A, 43-D, 44-B, 45-C, 46-C, 47-A, 48-D, 49-A, 50-D, 51-B, 52-E, 53-D, 54-B, 55-A, 56-C, 57-C, 58-A, 59-A, 60-C, 61-A, 62-A, 63-E, 64-E, 65-A, 66-B, 67-C, 68-E, 69-E, 70-D, 71-E, 72-A, 73-E, 74-C, 75-B, 76-B, 77-D, 78-B, 79-A, 80-E, 81-B, 82-A, 83-E, 84-D, 85-C, 86-E, 87-E, 88-D, 89-A, 90-E, 91-D, 92-E, 93-C, 94-D, 95-A, 96-C, 97-C, 98-E, 99-A, 100-A,